



Төлбөрийн баталгааны сангийн зөвлөлийн 2020 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 02 тоот тогтоолын хавсралт

**ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ САНГИЙН
ХУРИМТЛАЛ ТООЦОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэ журмаар “Арилжааны төлбөр тооцоо” ХХК (цаашид “Клирингийн төв” гэх)-ийн “Үнэт цаасны клирингийн журам”-д тодорхойлсон Төлбөрийн баталгааны сангийн хуримтлал (цаашид “Сангийн хуримтлал” гэх)-ын хэмжээг тодорхойлохтой холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2 Энэхүү журам нь батлагдсан өдрөөс хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд Зөвлөлийн хурлын шийдвэрээр нэмэлт өөрчлөлт оруулна.

Хоёр. Сангийн хуримтлал

- 2.1 Сангийн хуримтлалын хэмжээг улирал бүрийн эхний ажлын өдөр шинэчлэн тогтооно.
- 2.2 Сангийн хуримтлалыг дараах аргаар тодорхойлно. Үүнд:
 - 2.2.1 Клирингийн гишүүдийн өмнөх улирлын үнэт цаасны арилжаа, клирингийн дүнг арилжааны өдөр бүрээр тодорхойлно.
 - 2.2.2 Энэ журмын 2.2.1-д заасан дүнгээс хамгийн өндөр худалдан авах дүн бүхий нэг арилжааны өдрийг сонгоно.
 - 2.2.3 Энэ журмын 2.2.2-т заасан нэг арилжааны өдрийн дүнгээс хамгийн өндөр худалдан авах дүн бүхий хоёр клирингийн гишүүний худалдан авах дүнгээс барьцааны дүнг хасан үлдэгдэл төлбөрийн үүргийг тодорхойлно.
 - 2.2.4 Энэ журмын 2.2.3-д заасан хамгийн өндөр худалдан авах дүн бүхий хоёр клирингийн гишүүний худалдан авах дүнгээс барьцааны дүнг хасан үлдэгдэл төлбөрийн үүргийг тодорхойлно.
 - 2.2.5 Энэ журмын 2.2.4-д заасан хоёр клирингийн гишүүний үлдэгдэл төлбөрийн үүргийн нийлбэрээс 20 хувиар тооцон нийт эрсдэлийг тодорхойлно.
 - 2.2.6 Энэ зааврын 2.2.5-д тодорхойлсон нийт эрсдэлийн дүнгээр Сангийн хуримтлалын хэмжээг тогтооно.

Гурав. Клирингийн гишүүний байршуулах хуримтлал

- 3.1 Сангийн хуримтлалд байршуулах Клирингийн төвийн нэмэлт хөрөнгийн дүнг Клирингийн төвийн Төлөөлөн удирдах зөвлөл тогтооно.



- 3.2 Сангийн хуримтлалын дүнгээс Клирингийн төвийн нэмэлт хөрөнгийн дүнг хасч Клирингийн гишүүдийн Санд байршуулах нийт хуримтлалын хэмжээг тодорхойлно.
- 3.3 Клирингийн гишүүн бүрийн Санд байршуулах суурь хуримтгал 1.0 сая төгрөг байна.
- 3.4 Клирингийн гишүүдийн Санд байршуулах нийт хуримтлалаас Клирингийн гишүүдийн нийт суурь хуримтлалын дүнг хасч Клирингийн гишүүдийн Санд байршуулах нэмэлт хуримтлалын нийт дүнг тодорхойлно.
- 3.5 Клирингийн гишүүдийн Санд байршуулах нэмэлт хуримтлалын нийт дүнг бүх клирингийн гишүүний өмнөх улиралд гүйцэтгэсэн клирингийн дүнтэй хувь тэнцүүлэн нэг клирингийн гишүүний Санд байршуулах нэмэлт хуримтлалын дүнг тодорхойлно.

Дөрөв. Бусад

- 4.1 Сангийн хуримтлалыг Клирингийн төвөөс ирүүлсэн нэхэмжлэлийн дагуу улирал бүрийн ажлын эхний 3 хоногт багтаан Сангийн дансанд байршуулна.
- 4.2 Клирингийн гишүүний Санд байршуулах нэмэлт хуримтлалын хэмжээ өмнөх улирлын дүнгээс буурсан тохиолдолд Клирингийн гишүүний нэхэмжлэлийг үндэслэн зөрүү хуримтлалыг Клирингийн гишүүнд буцаан олгоно.